

“Си и си инвестмент ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2025 оны 11 сарын 04 өдрийн 1030 тоот Тогтоолын Хавсралт № 1

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь компанийн засаглалын чиглэлийн дотоод зохицуулалтын баримт бичгийн нэг бөгөөд компанийн бүх албан тушаалтан мөрдөн ажиллах үүрэгтэй.
- 1.3 Энэхүү журмаар компанийн нягтлан бодох бүртгэлийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-д нийцүүлэх, дотоод аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн байдалд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааны журмыг боловсруулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.4 Хороо нь ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, компанид үр ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд мэдлэг, ур чадвартай захирал, удирдах ажилтныг олж тогтоон, улмаар компанийн бизнесийн зорилтдоо хүрэх, бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, компанийн засаглалыг ил тод, үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
- 1.5 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн ТУЗ-ийн хурлаар тухайн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

### ХОЁР. ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1 Хороо нь 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд түүний 1/3-ээс доошгүй гишүүн нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 2.2 Хорооны дарга, гишүүдийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос санал болгож, хорооны хурлаар, хорооны хурлаас гишүүдийн олонхийн саналаар даргыг сонгоно.
- 2.3 Хорооны дарга, гишүүдийг томилохдоо тэдгээрийн мэргэжил, ур чадварыг харгалзан үзнэ.
- 2.4 Компанийн Гүйцэтгэх захирал хорооны гишүүн байж болохгүй.
- 2.5 Гишүүний бүрэн эрхийн хугацаа нь хорооны бүрэн эрхийн хугацаатай адил байна.
- 2.6 ТУЗ нь хорооны гишүүнийг үндэслэлтэйгээр хугацаанаас нь өмнө ажлаас чөлөөлөх эсвэл хорооны бүрэлдэхүүнийг бүхэлд нь шинэчлэх эрхтэй.
- 2.7 Хорооны дарга, гишүүд нь дараагийн дарга, гишүүд албан ёсоор томилогдож, ТУЗ-өөс хорооны гишүүнээс чөлөөлөх шийдвэр гартал хорооны ажил үүргээ гүйцэтгэнэ.
- 2.8 Аудитын хорооны гишүүд дараах шаардлагыг хангасан байна.
  - 2.8.1 Компанийн тайлан тэнцэл, орлогын тайлан, мөнгөн урсгалын тайлан,

өмчийн өөрчлөлтийн тайлан зэрэг санхүүгийн суурь тайлангуудыг шинжлэх, дүгнэлт гаргах чадвартай байх;

2.8.2 Компанийн санхүүгийн болон эрсдэл, хяналтын нэгжийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах чадвартай байх;

2.8.3 Банк, санхүүгийн салбарт мөрдөгдөж буй хууль зүйн орчин, түүний хүрээнд гарах аливаа өөрчлөлт, түүний компанид үзүүлж болзошгүй үр дагавар, нөлөөллийг шинжлэх, дүгнэх ажлын мэдлэг туршлагатай байх;

2.8.4 Аудитын хороо нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд хуулийн болон бусад чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүдийг ажиллуулж болно.

### **ГУРАВ. ХОРООНЫ ХУРАЛ**

- 3.1 Хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хорооны хурал бөгөөд хурал нь ээлжит болон ээлжит бус гэсэн хоёр хэлбэртэй байна. Ээлжит хурлыг улиралд нэг удаа хийх ба түүгээр хэлэлцэх асуудлыг тухайн жилийн эхний хурлаар баталж холбогдох албан тушаалтанд хүргүүлэх ба ээлжит бус хурлыг шаардлагатай тохиолдолд тухай бүрт зарлан хуралдаж болно. Хурлын хуваарь болон хурлаар хэлэлцэх асуудлыг хорооноос тухай бүр батлана.
- 3.2 Хорооны хурлыг хуралдуулах саналыг хорооны гишүүд болон компанийн Гүйцэтгэх удирдлагаас гаргаж болно. Энэхүү саналаа бичгээр гаргах бөгөөд түүнд хэлэлцэх асуудлын нэр, түүнийг хэлэлцэх шалтгааныг тусгасан байна. Мөн ТУЗ-ийн шийдвэрээр болон шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн болон дотоод аудитуудын саналаар хурлыг зарлан хуралдуулж болно.
- 3.3 Хорооны хурлыг хорооны дарга удирдах ба түүний эзгүйд тухайн хурлаас томилсон дарга удирдана.
- 3.4 Хорооны хурал нь гишүүдийн олонхийн ирцтэйгээр хүчин төгөлдөр болох ба хурлаас гарах шийдвэр тухайн хуралд оролцсон гишүүдийн дийлэнхи олны саналаар гарна. Санал тэнцсэн тохиолдолд хорооны дарга шийдвэрлэх санал өгнө.
- 3.5 Гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд тухайн гишүүн хурлын явцыг сонсож, санал бодлоо илэрхийлж болох арга хэрэгслийг ашиглан утсаар эсвэл видео хэлбэрээр оролцож болохоос гадна хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт саналаа бичгээр илгээх замаар оролцож болно. Эдгээр тохиолдолд тухайн гишүүнийг хуралд оролцсонд тооцно.
- 3.6 Хорооны хуралд шаардлагатай тохиолдолд компанийн удирдлагууд болон ажилтнууд, гадны зөвлөхийг урьж оролцуулж болно.
- 3.7 ТУЗ-ийн ажлын алба нь хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, материалыг холбогдох албан тушаалтнаас урьдчилан гаргуулж, гишүүдэд хүргэх ажлыг зохион байгуулахаас гадна хорооны хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж хадгалах ажлыг хариуцна.
- 3.8 Хорооны хурлаас хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд гарах шийдвэр нь ТУЗ болон компанийн Гүйцэтгэх удирдлагад зориулсан дүгнэлт, санал, зөвлөмж хэлбэртэй байна.

### **ДӨРӨВ. ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ**

- 4.1 Аудитын хорооны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д компанийн дотоод болон хөндлөнгийн аудит, дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлан, ёс зүйн дүрэм, хууль журмын

хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, аудитын үйл ажиллагааны үр дүнг Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д мэдээлэх, байгууллагын сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд оршино. Хороо нь дараах чиглэлээр үнэлэлт, дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах зөвлөмж болон саналыг гаргана.

- 4.1.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүү бүртгэл нь СТОУС-д шийцэж байгаа эсэх;
  - 4.1.2 Санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, үйл ажиллагааны байдал, санхүүгийн төсөв төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх, төсөв төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах;
  - 4.1.3 Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүний ажлын хөлсийг тохиролцож тогтоох талаар санал боловсруулах;
  - 4.1.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
  - 4.1.5 Санхүү, татвар, үйл ажиллагааны чиглэлээр хийгдсэн дотоод болон хөндлөнгийн аудитын тайлан дүгнэлттэй танилцах, тэдгээрийн илэрсэн зөрчлийг арилгасан эсэх, зөвлөмжийн хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавих;
  - 4.1.6 Компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх, дүрэм журам, ёс зүйн хэм хэмжээг баримталж байгаа эсэхэд дүгнэлт өгөх;
  - 4.1.7 Компанийн үйл ажиллагаа нээлттэй, мэдээллийн ил тод байдал хангагдаж байгаа эсэх, гадагш мэдээллэж байгаа мэдээллийн үнэн зөв байдал, компанийн нууц, дотоод мэдээлэл алдагдсан эсэх, түүнийг буруугаар ашигласан эсэхийг илрүүлэх, хянах;
  - 4.1.8 ТУЗ-ийн тодорхойлсон бусад асуудал
- 4.2 Хороо нь дотоод аудит болон дотоод хяналтын системийн үр дүнд хяналт тавих чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 4.2.1 Санхүүгийн тайланд хийгдэж буй дотоод болон хөндлөнгийн аудитуудын шалгалтын хамрах хүрээ, дотоод хяналтын талаар аудитаар олж илрүүлсэн ноцтой зөрчлийн асуудлууд, зөвлөмжийн талаар компанийн Гүйцэтгэх удирдлагатай тусгайлан хэлэлцэж дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх удирдлагаас авбал зохих арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;
  - 4.2.2 Санхүүгийн болон бусад залилан үүсэх эрсдлийг хаах, түүнийг илрүүлэх, түүний талаар мэдээлэл өгөх тухай компанийн дүрэм журам бий болгох;
  - 4.2.3 Дотоод аудит зохион байгуулах журам чиглэлийг ТУЗ-аар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудитын албаны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх;
  - 4.2.4 Компанийн дотоод хяналтын тогтолцооны зөв зохистой, үр ашигтай байдлыг хэлэлцэх, дотоод хяналтын системийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой заавар, журмын хэрэгжилтэд дүгнэлт гаргах, дотоод хяналтыг боловсронгуй болгох санал дүгнэлтийг гүйцэтгэх удирдлагад зөвлөмж болгох;
  - 4.2.5 Дотоод аудитын тайлан мэдээтэй танилцаж, тайланд нэмж тусгах санал зөвлөмж гаргаж ажиллах;
  - 4.2.6 Дотоод аудиторын тайлангийн үр дүнгээр илэрсэн асуудлын мөн

чанарын таньж мэдсэний үндсэн дээр зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг тодорхойлж, компанийн удирдлага, холбогдох албан тушаалтанд үүрэг чиглэл өгөх;

4.2.7 Компанийн дотоод хяналтын орчны зөв зохистой байдлыг хянах;

4.3 Хороо нь санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудит, түүний бие даасан байдлыг хянан шалгах үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.3.1 ТУЗ-аар батлуулахаас өмнө, үнэ хөлсийг хянан шалгаж, аудитын шалгалт чанарын өндөр түвшинд хийгдэхэд хангалттай хэмжээнд байгааг баталгаажуулах;

4.3.2 Аудитын агуулга, цар хүрээний талаар хөндлөнгийн аудитортой зөвшилцөх;

4.3.3 Хөндлөнгийн аудитын явцад хяналт тавьж, аудитын гэрээний дагуу ажлын үр дүн, хэрэгжилтэд шаардлага тавин ажиллах;

4.3.4 Хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтран хийгдсэн ажлын үр дүнд дүн шинжилгээ хийх;

4.3.5 Хөндлөнгийн аудитын зүгээс Удирдлагын захидлаар дамжуулан өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;

#### **ТАВ. ХОРОО БОЛОН ТҮҮНИЙ ГИШҮҮДИЙН БҮРЭН ЭРХ**

5.1 Хороо нь үйл ажиллагааныхаа талаар улирал бүр ТУЗ-д танилцуулж шаардлагатай шийдвэрийг гаргуулж ажиллах;

5.2 Хороо нь компанийн дотоод, гадаад аудит, дотоод хяналт, хянан нийцүүлэлт, эрсдэлийн удирдлагын нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт, тухайн жилд хийсэн ажлын талаар жил бүрийн төгөсгөд нэгдсэн дүгнэлтийг гаргаж ТУЗ-д танилцуулдаг байх;

5.3 Хороо нь компани дээр тухайн жилд хяналт шалгалт, аудитын талаар хийгдсэн хийгдсэн ажлын ерөнхий тоймыг компанийн жилийн тайланд тусгах ажлыг удирдан зохион байгуулдаг байх;

5.4 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд аудитын хорооны үүрэг хариуцлага, ажлын гүйцэтгэлийн талаар мэдээлэл хийх;

5.5 Хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.5.1 Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны бүхий л мэдээлэлд хяналт тавих;

5.5.2 Хөндлөнгийн аудит томилох, төлбөрийн хэмжээг тогтоох, хөндлөнгийн аудитын явцад хяналт тавих, аудитын гэрээг цуцлах;

5.5.3 Дотоод аудитын албаны удирдлага, ажилтанг томилох, тэдгээр ажилтнуудыг ажлаас чөлөөлөх, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах;

5.5.4 Гүйцэтгэх удирдлагын аль нэг гишүүн болон компанийн бүх ажилтнууд хамтран ажиллах;

5.5.5 Компанийн захирал, ажилтан, мэргэжилтнийг өөрийн хуралд ажиглагчаар оролцуулах, мөн асуулт асуух, тайлбар болон тодруулга авах;

- 5.5.6 Шаардлагатай тохиолдолд компанийн зардлаар гадны хараат бус мэргэжлийн хуулийн зөвлөх болон мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн үнэлгээчин бусад мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах, холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоог хангаж ажиллах;
- 5.5.7 Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар компанийн удирдлагад үүрэг даалгавар заавар зөвлөмж өгөх;
- 5.5.8 Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах, зөрчил алдаа гаргасан бол түүнийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналын ТУЗ-д оруулах;
- 5.5.9 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахыг шаардах, түүгээр хэлэлцэх асуудлыг санал болгох;
- 5.5.10 Журамд заасан чиг үүргийн хүрээнд ТУЗ-аас шаардсан бусад үүргийг гүйцэтгэх;
- 5.2. Хорооны гишүүд дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.2.1 Хорооны ажил, үйл ажиллагаа бүх хуралд оролцох;
- 5.2.2 Салбарын болон зах зээлийн хандлага мөн мэдээллийн технологи, компанид стратегийн ач холбогдолтой бусад чиглэлийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэх;
- 5.2.3 Хорооны гишүүд нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан Компанийн зүгээс танилцуулсан эсвэл шалгалтаар илрүүлсэн аливаа нууц болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд болон шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх;
- 5.2.4 Хорооны дүрмийн биелэлтүүдийг хянах мөн хороо, түүний гишүүдийн ажлын талаар жил бүр хяналт, дүгнэлт гаргах;

## **ЗУРГАА. ХОРООНЫ ХУРЛЫН ДЭГ, ЖУРАМ**

- 6.1 Хороог гишүүдийг олонхийн саналаар томилсон дарга удирдана.
- 6.2 Хорооны нарийн бичгийн даргыг хорооны гишүүдээс санал болгосны дагуу хорооны хурлаар томилно.
- 6.3 Хорооны нарийн бичгийн дарга нь хороог ажиллах нөхцөл боломжоор хангаж ажлыг гүйцэтгэнэ.
- 6.4 Хорооны гишүүд компанийн үндсэн удирдлага болон бусад холбогдох ажилтнуудтай харилцан ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар, туршлагатай байна.
- 6.5 Хорооны ажил, үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хурал байна. Хорооны хурлыг хорооны үйл ажиллагаа, үндсэн үүргийг цаг тухайд гүйцэтгэхэд шаардагдах тогтмол хугацаанд хуралдуулна.
- 6.6 Ээлжит хурлыг улиралд нэг удаа хуралдуулна. Ээлжит бус хурлыг компанийн үйл ажиллагаа, шийдвэрлэх асуудлаас хамааран хэдийд ч хуралдуулж болно. Хэрэв ТУЗ-ийн хурлаар хорооны чиг үүрэгтэй холбоотой асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн бол хороо ТУЗ-ийн хурал болох өдрөөс өмнө хуралдана.
- 6.7 Хурлыг хорооны дарга, гишүүний санал эсвэл ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн явуулна.
- 6.8 Хурлыг гишүүд биечлэн ирсэн тохиолдолд эсвэл биечлэн ирээгүй гишүүдийн

бичгээр үйлдсэн зөвшөөрлийн дагуу мөн видео болон аудио хэлбэрээр явуулж болно.

- 6.9 Хорооны нарийн бичгийн дарга хурал болохоос дор хаяж 3 хоногийн өмнө хорооны гишүүдэд хурлын тов ба хөтөлбөрийн талаар урьдчилан мэдэгдэж, хөтөлбөрт тусгагдсан асуудалтай холбоотой шаардлагатай мэдээллээр хангана. Энэхүү мэдэгдлийг утас, факс, шуудан болон цахим шуудан зэрэг хорооны гишүүдийн харилцан тохиромжтой хэлбэрээр хийнэ.
- 6.10 Хурлын тэмдэглэлд Хорооны дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулна.
- 6.11 Хорооны тодорхой асуудал хэлэлцэж дуусмагц санал дүгнэлтээ бичгээр үйлдэж, уг дүгнэлтээ компанийн дотоод дүрмийн дагуу ТУЗ-ийн дарга, эсвэл ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлэн өгнө. Хорооны дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа гишүүн өөрийн дүгнэлтийг мэдүүлнэ.
- 6.12 Хорооны хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр, санал зөвлөмж гаргана.

#### **ДОЛОО. БУСАД**

- 7.1 Хорооны хурлын чиг үүргийн дагуу дотоод болон хөндлөнгийн аудитын тайлан мэдээ, бусад холбогдох асуудлаар хэлэлцэн, хорооноос санал зөвлөмж гаргана.
- 7.2 Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба түүний хэрэгжилтэнд Аудитын хорооноос хяналт тавьж үр дүнг ТУЗ-д мэдээллэнэ.
- 7.3 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар жил бүрийн төгсгөлд холбогдох талуудаас санал авч, ирсэн саналыг нэгтгэн ТУЗ-д танилцуулан асуудлыг шийдвэрлүүлж байна.

“Си и си инвестмент ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2025 оны 11 сарын 04 өдрийн 45 тоот Тогтоолын Хавсралт № 1

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь компанийн засаглалын чиглэлийн дотоод зохицуулалтын баримт бичгийн нэг бөгөөд компанийн бүх албан тушаалтан мөрдөн ажиллах үүрэгтэй.
- 1.3 Энэхүү журмаар компанийн нягтлан бодох бүртгэлийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-д нийцүүлэх, дотоод аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн байдалд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааны журмыг боловсруулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.4 Хороо нь ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, компанид үр ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд мэдлэг, ур чадвартай захирал, удирдах ажилтныг олж тогтоон, улмаар компанийн бизнесийн зорилтдоо хүрэх, бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, компанийн засаглалыг ил тод, үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
- 1.5 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн ТУЗ-ийн хурлаар тухайн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

### ХОЁР. ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1 Хороо нь 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд түүний 1/3-ээс доошгүй гишүүн нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 2.2 Хорооны дарга, гишүүдийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос санал болгож, хорооны хурлаар, хорооны хурлаас гишүүдийн олонхийн саналаар даргыг сонгоно.
- 2.3 Хорооны дарга, гишүүдийг томилохдоо тэдгээрийн мэргэжил, ур чадварыг харгалзан үзнэ.
- 2.4 Компанийн Гүйцэтгэх захирал хорооны гишүүн байж болохгүй.
- 2.5 Гишүүний бүрэн эрхийн хугацаа нь хорооны бүрэн эрхийн хугацаатай адил байна.
- 2.6 ТУЗ нь хорооны гишүүнийг үндэслэлтэйгээр хугацаанаас нь өмнө ажлаас чөлөөлөх эсвэл хорооны бүрэлдэхүүнийг бүхэлд нь шинэчлэх эрхтэй.
- 2.7 Хорооны дарга, гишүүд нь дараагийн дарга, гишүүд албан ёсоор томилогдож, ТУЗ-өөс хорооны гишүүнээс чөлөөлөх шийдвэр гаргал хорооны ажил үүргээ гүйцэтгэнэ.
- 2.8 Аудитын хорооны гишүүд дараах шаардлагыг хангасан байна.
  - 2.8.1 Компанийн тайлан тэнцэл, орлогын тайлан, мөнгөн урсгалын тайлан,

өмчийн өөрчлөлтийн тайлан зэрэг санхүүгийн суурь тайлангуудыг шинжлэх, дүгнэлт гаргах чадвартай байх;

2.8.2 Компанийн санхүүгийн болон эрсдэл, хяналтын нэгжийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах чадвартай байх;

2.8.3 Банк, санхүүгийн салбарт мөрдөгдөж буй хууль зүйн орчин, түүний хүрээнд гарах аливаа өөрчлөлт, түүний компанид үзүүлж болзошгүй үр дагавар, нөлөөллийг шинжлэх, дүгнэх ажлын мэдлэг туршлагатай байх;

2.8.4 Аудитын хороо нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд хуулийн болон бусад чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүдийг ажиллуулж болно.

### **ГУРАВ. ХОРООНЫ ХУРАЛ**

- 3.1 Хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хорооны хурал бөгөөд хурал нь ээлжит болон ээлжит бус гэсэн хоёр хэлбэртэй байна. Ээлжит хурлыг улиралд нэг удаа хийх ба түүгээр хэлэлцэх асуудлыг тухайн жилийн эхний хурлаар баталж холбогдох албан тушаалтанд хүргүүлэх ба ээлжит бус хурлыг шаардлагатай тохиолдолд тухай бүрт зарлан хуралдаж болно. Хурлын хуваарь болон хурлаар хэлэлцэх асуудлыг хорооноос тухай бүр батлана.
- 3.2 Хорооны хурлыг хуралдуулах саналыг хорооны гишүүд болон компанийн Гүйцэтгэх удирдлагаас гаргаж болно. Энэхүү саналаа бичгээр гаргах бөгөөд түүнд хэлэлцэх асуудлын нэр, түүнийг хэлэлцэх шалтгааныг тусгасан байна. Мөн ТУЗ-ийн шийдвэрээр болон шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн болон дотоод аудитуудын саналаар хурлыг зарлан хуралдуулж болно.
- 3.3 Хорооны хурлыг хорооны дарга удирдах ба түүний эзгүйд тухайн хурлаас томилсон дарга удирдана.
- 3.4 Хорооны хурал нь гишүүдийн олонхийн ирцтэйгээр хүчин төгөлдөр болох ба хурлаас гарах шийдвэр тухайн хуралд оролцсон гишүүдийн дийлэнхи олны саналаар гарна. Санал тэнцсэн тохиолдолд хорооны дарга шийдвэрлэх санал өгнө.
- 3.5 Гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд тухайн гишүүн хурлын явцыг сонсож, санал бодлоо илэрхийлж болох арга хэрэгслийг ашиглан утсаар эсвэл видео хэлбэрээр оролцож болохоос гадна хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт саналаа бичгээр илгээх замаар оролцож болно. Эдгээр тохиолдолд тухайн гишүүнийг хуралд оролцсонд тооцно.
- 3.6 Хорооны хуралд шаардлагатай тохиолдолд компанийн удирдлагууд болон ажилтнууд, гадны зөвлөхийг урьж оролцуулж болно.
- 3.7 ТУЗ-ийн ажлын алба нь хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, материалыг холбогдох албан тушаалтнаас урьдчилан гаргуулж, гишүүдэд хүргэх ажлыг зохион байгуулахаас гадна хорооны хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж хадгалах ажлыг хариуцна.
- 3.8 Хорооны хурлаас хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд гарах шийдвэр нь ТУЗ болон компанийн Гүйцэтгэх удирдлагад зориулсан дүгнэлт, санал, зөвлөмж хэлбэртэй байна.

### **ДӨРӨВ. ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ**

- 4.1 Аудитын хорооны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д компанийн дотоод болон хөндлөнгийн аудит, дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлан, ёс зүйн дүрэм, хууль журмын

хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, аудитын үйл ажиллагааны үр дүнг Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д мэдээлэх, байгууллагын сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд оршино. Хороо нь дараах чиглэлээр үнэлэлт, дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах зөвлөмж болон саналыг гаргана.

- 4.1.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүү бүртгэл нь СТОУС-д нийцэж байгаа эсэх;
  - 4.1.2 Санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, үйл ажиллагааны байдал, санхүүгийн төсөв төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх, төсөв төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах;
  - 4.1.3 Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүний ажлын хөлсийг тохиролцож тогтоох талаар санал боловсруулах;
  - 4.1.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
  - 4.1.5 Санхүү, татвар, үйл ажиллагааны чиглэлээр хийгдсэн дотоод болон хөндлөнгийн аудитын тайлан дүгнэлттэй танилцах, тэдгээрийн илэрсэн зөрчлийг арилгасан эсэх, зөвлөмжийн хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавих;
  - 4.1.6 Компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх, дүрэм журам, ёс зүйн хэм хэмжээг баримталж байгаа эсэхэд дүгнэлт өгөх;
  - 4.1.7 Компанийн үйл ажиллагаа нээлттэй, мэдээллийн ил тод байдал хангагдаж байгаа эсэх, гадагш мэдээллэж байгаа мэдээллийн үнэн зөв байдал, компанийн нууц, дотоод мэдээлэл алдагдсан эсэх, түүнийг буруугаар ашигласан эсэхийг илрүүлэх, хянах;
  - 4.1.8 ТУЗ-ийн тодорхойлсон бусад асуудал
- 4.2 Хороо нь дотоод аудит болон дотоод хяналтын системийн үр дүнд хяналт тавих чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 4.2.1 Санхүүгийн тайланд хийгдэж буй дотоод болон хөндлөнгийн аудитуудын шалгалтын хамрах хүрээ, дотоод хяналтын талаар аудитаар олж илрүүлсэн ноцтой зөрчлийн асуудлууд, зөвлөмжийн талаар компанийн Гүйцэтгэх удирдлагатай тусгайлан хэлэлцэж дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх удирдлагаас авбал зохих арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;
  - 4.2.2 Санхүүгийн болон бусад залилан үүсэх эрсдлийг хаах, түүнийг илрүүлэх, түүний талаар мэдээлэл өгөх тухай компанийн дүрэм журам бий болгох;
  - 4.2.3 Дотоод аудит зохион байгуулах журам чиглэлийг ТУЗ-аар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудитын албаны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх;
  - 4.2.4 Компанийн дотоод хяналтын тогтолцооны зөв зохистой, үр ашигтай байдлыг хэлэлцэх, дотоод хяналтын системийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой заавар, журмын хэрэгжилтэд дүгнэлт гаргах, дотоод хяналтыг боловсронгуй болгох санал дүгнэлтийг гүйцэтгэх удирдлагад зөвлөмж болгох;
  - 4.2.5 Дотоод аудитын тайлан мэдээтэй танилцаж, тайланд нэмж тусгах санал зөвлөмж гаргаж ажиллах;
  - 4.2.6 Дотоод аудиторовын тайлангийн үр дүнгээр илэрсэн асуудлын мөн

чанарын таньж мэдсэний үндсэн дээр зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг тодорхойлж, компанийн удирдлага, холбогдох албан тушаалтанд үүрэг чиглэл өгөх;

4.2.7 Компанийн дотоод хяналтын орчны зөв зохистой байдлыг хянах;

4.3 Хороо нь санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудит, түүний бие даасан байдлыг хянан шалгах үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.3.1 ТУЗ-аар батлуулахаас өмнө, үнэ хөлсийг хянан шалгаж, аудитын шалгалт чанарын өндөр түвшинд хийгдэхэд хангалттай хэмжээнд байгааг баталгаажуулах;

4.3.2 Аудитын агуулга, цар хүрээний талаар хөндлөнгийн аудитортой зөвшилцөх;

4.3.3 Хөндлөнгийн аудитын явцад хяналт тавьж, аудитын гэрээний дагуу ажлын үр дүн, хэрэгжилтэд шаардлага тавин ажиллах;

4.3.4 Хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтран хийгдсэн ажлын үр дүнд дүн шинжилгээ хийх;

4.3.5 Хөндлөнгийн аудитын зүгээс Удирдлагын захидлаар дамжуулан өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;

#### **ТАВ. ХОРОО БОЛОН ТҮҮНИЙ ГИШҮҮДИЙН БҮРЭН ЭРХ**

5.1 Хороо нь үйл ажиллагааныхаа талаар улирал бүр ТУЗ-д танилцуулж шаардлагатай шийдвэрийг гаргуулж ажиллах;

5.2 Хороо нь компанийн дотоод, гадаад аудит, дотоод хяналт, хянан нийцүүлэлт, эрсдэлийн удирдлагын нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт, тухайн жилд хийсэн ажлын талаар жил бүрийн төгөсгөд нэгдсэн дүгнэлтийг гаргаж ТУЗ-д танилцуулдаг байх;

5.3 Хороо нь компани дээр тухайн жилд хяналт шалгалт, аудитын талаар хийгдсэн хийгдсэн ажлын ерөнхий тоймыг компанийн жилийн тайланд тусгах ажлыг удирдан зохион байгуулдаг байх;

5.4 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд аудитын хорооны үүрэг хариуцлага, ажлын гүйцэтгэлийн талаар мэдээлэл хийх;

5.5 Хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.5.1 Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны бүхий л мэдээлэлд хяналт тавих;

5.5.2 Хөндлөнгийн аудит томилох, төлбөрийн хэмжээг тогтоох, хөндлөнгийн аудитын явцад хяналт тавих, аудитын гэрээг цуцлах;

5.5.3 Дотоод аудитын албаны удирдлага, ажилтанг томилох, тэдгээр ажилтнуудыг ажлаас чөлөөлөх, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах;

5.5.4 Гүйцэтгэх удирдлагын аль нэг гишүүн болон компанийн бүх ажилтнууд хамтран ажиллах;

5.5.5 Компанийн захирал, ажилтан, мэргэжилтнийг өөрийн хуралд ажиглагчаар оролцуулах, мөн асуулт асуух, тайлбар болон тодруулга авах;

- 5.5.6 Шаардлагатай тохиолдолд компанийн зардлаар гадны хараат бус мэргэжлийн хуулийн зөвлөх болон мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн үнэлгээчин бусад мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах, холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоог хангаж ажиллах;
  - 5.5.7 Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар компанийн удирдлагад үүрэг даалгавар заавар зөвлөмж өгөх;
  - 5.5.8 Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах, зорчил алдаа гаргасан бол түүнийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналын ТУЗ-д оруулах;
  - 5.5.9 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахыг шаардах, түүгээр хэлэлцэх асуудлыг санал болгох;
  - 5.5.10 Журамд заасан чиг үүргийн хүрээнд ТУЗ-аас шаардсан бусад үүргийг гүйцэтгэх;
- 5.2. Хорооны гишүүд дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.2.1 Хорооны ажил, үйл ажиллагаа бүх хуралд оролцох;
  - 5.2.2 Салбарын болон зах зээлийн хандлага мөн мэдээллийн технологи, компанид стратегийн ач холбогдолтой бусад чиглэлийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэх;
  - 5.2.3 Хорооны гишүүд нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан Компанийн зүгээс танилцуулсан эсвэл шалгалтаар илрүүлсэн аливаа нууц болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд болон шууд бус байдлаар бусад задруулахгүй байх, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх;
  - 5.2.4 Хорооны дүрмийн биелэлтүүдийг хянах мөн хороо, түүний гишүүдийн ажлын талаар жил бүр хяналт, дүгнэлт гаргах;

## **ЗУРГАА. ХОРООНЫ ХУРЛЫН ДЭГ, ЖУРАМ**

- 6.1 Хороог гишүүдийг олонхийн саналаар томилсон дарга удирдана.
- 6.2 Хорооны нарийн бичгийн даргыг хорооны гишүүдээс санал болгосны дагуу хорооны хурлаар томилно.
- 6.3 Хорооны нарийн бичгийн дарга нь хороог ажиллах нөхцөл боломжоор хангаж ажлыг гүйцэтгэнэ.
- 6.4 Хорооны гишүүд компанийн үндсэн удирдлага болон бусад холбогдох ажилтнуудтай харилцан ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар, туршлагатай байна.
- 6.5 Хорооны ажил, үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хурал байна. Хорооны хурлыг хорооны үйл ажиллагаа, үндсэн үүргийг цаг тухайд гүйцэтгэхэд шаардагдах тогтмол хугацаанд хуралдуулна.
- 6.6 Ээлжит хурлыг улиралд нэг удаа хуралдуулна. Ээлжит бус хурлыг компанийн үйл ажиллагаа, шийдвэрлэх асуудлаас хамааран хэдийд ч хуралдуулж болно. Хэрэв ТУЗ-ийн хурлаар хорооны чиг үүрэгтэй холбоотой асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн бол хороо ТУЗ-ийн хурал болох өдрөөс өмнө хуралдана.
- 6.7 Хурлыг хорооны дарга, гишүүний санал эсвэл ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн явуулна.
- 6.8 Хурлыг гишүүд биечлэн ирсэн тохиолдолд эсвэл биечлэн ирээгүй гишүүдийн

бичгээр үйлдсэн зөвшөөрлийн дагуу мөн видео болон аудио хэлбэрээр явуулж болно.

- 6.9 Хорооны нарийн бичгийн дарга хурал болохоос дор хаяж 3 хоногийн өмнө хорооны гишүүдэд хурлын тов ба хөтөлбөрийн талаар урьдчилан мэдэгдэж, хөтөлбөрт тусгагдсан асуудалтай холбоотой шаардлагатай мэдээллээр хангана. Энэхүү мэдэгдлийг утас, факс, шуудан болон цахим шуудан зэрэг хорооны гишүүдийн харилцаа тохиромжтой хэлбэрээр хийнэ.
- 6.10 Хурлын тэмдэглэлд Хорооны дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулна.
- 6.11 Хорооны тодорхой асуудал хэлэлцэж дуусмагц санал дүгнэлтээ бичгээр үйлдэж, уг дүгнэлтээ компанийн дотоод дүрмийн дагуу ТУЗ-ийн дарга, эсвэл ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлэн өгнө. Хорооны дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа гишүүн өөрийн дүгнэлтийг мэдүүлнэ.
- 6.12 Хорооны хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр, санал зөвлөмж гаргана.

#### **ДОЛОО. БУСАД**

- 7.1 Хорооны хурлын чиг үүргийн дагуу дотоод болон хөндлөнгийн аудитын тайлан мэдээ, бусад холбогдох асуудлаар хэлэлцэн, хорооноос санал зөвлөмж гаргана.
- 7.2 Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба түүний хэрэгжилтэнд Аудитын хорооноос хяналт тавьж үр дүнг ТУЗ-д мэдээллэнэ.
- 7.3 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар жил бүрийн төгсгөлд холбогдох талуудаас санал авч, ирсэн саналыг нэгтгэн ТУЗ-д танилцуулан асуудлыг шийдвэрлүүлж байна.



# CECInvestment

СИ-И-СИ ИНВЕСТМЕНТ ББСБ ХХК

20...<sup>25</sup> оны <sup>11</sup> сарын <sup>04</sup> өдөр

№ <sup>25</sup>/030

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Журам батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76-р зүйл болон 81-р зүйл, “Си и си инвестмент ББСБ” ХХК-ийн /цаашид “Компани” гэх/ Дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дугаар сарын 04-ний өдрийн цахим хурлын санал хураалтын хуудсыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх “Дотоод аудитын хороо”-ны журмыг Хавсралт 1 ёсоор баталсугай.
2. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Х.ГИЙМАА

3F, Monnis Building, Stadium Orgil-22,  
Great Mongolian street, 18th khoroo,  
Khan-Uul district, Ulaanbaatar 17011, Mongolia

(T) +976 7772 5511  
(M) ceci@upg.mn  
(W) www.ceci.mn

Журам батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 р зүйл болон 81 р зүйл, “Си и си инвестмент ББСБ” ХХК-ийн /цаашид “Компани” гэх/ Дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дугаар сарын 04-ний өдрийн цахим хурлын санал хураалтын хуудсыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх “Дотоод аудитын хороо”-ны журмыг Хавсралт 1 ёсоор баталсугай.
2. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

| Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарах тогтоолын төслийн хүрээнд санал хураалтыг 2025 оны 11 сарын 04 өдөр явуулав. |                 |                                                             |            |           |
|---------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|-------------------------------------------------------------|------------|-----------|
| №                                                                                                             | ТУЗ-ийн гишүүн  | Санал                                                       |            | Огноо     |
|                                                                                                               |                 | Зөвшөөрсөн                                                  | Татгалзсан |           |
| 1                                                                                                             | Х.Гиймаа        | 2025.10.31 ний 18:20 цагт утсаар зөвшөөрсөн санал өгөв.     |            |           |
| 2                                                                                                             | Ц.Ууганбаяр     | 2025.10.31 ний 15:01 цагт ил хэллээр зөвшөөрсөн санал өгөв. |            |           |
| 3                                                                                                             | Н.Урантуяа      | 2025.10.30 нх 15:43 цагт ил хэллээр зөвшөөрсөн санал өгөв.  |            |           |
| 4                                                                                                             | Б.Баярмаа       | 2025.11.04-ний 12:42 цагт зөвшөөрсөн санал өгөв             |            | и хэллээр |
| 5                                                                                                             | П.Ундрах-Эрдэнэ | 2025.10.31 ний 15:08 цагт зөвшөөрсөн санал өгөв.            |            | и хэллээр |
| Санал хураалтын дүн                                                                                           |                 | 100%                                                        |            | Тайлбар:  |
| Шийдвэр: Тогтоолын 100% - ийн саналаар тогтоолыг төсөл батлав.                                                |                 |                                                             |            |           |